# НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

## ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 14 Улаанбаатар хот

**Байгууллагын дэргэдэх "Эцэг, эхийн зөвлөл"-ийн**
**2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тухай**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар "Эцэг, эхийн зөвлөл" 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн байнгын ажиллагаатай зөвлөл, комиссуудын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай А/24 дүгээр тушаалаар зөвлөлийн 2 гишүүнийг өөрчилсөн. 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/150 дугаар тушаалаар бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан.





Байгууллагын "Эцэг, эхийн зөвлөл"-ийн 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 70% -тай хэрэгжсэн байна.





Тус газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/135 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам батлагдсан бөгөөд 3.11-д "Албан хаагчдын ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны

ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.” заалтыг “Эцэг, эхийн зөвлөл”-өөс санаачлан тусгасан.

Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/304 дүгээр Чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу дараах ажлыг зохион байгуулсан.

1.Эцэг, эхийн зөвлөлийг 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулж, жил бүр төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн, тогтмол үйл ажиллагаа явуулж, холбогдох тайланг хүргүүлж ажиллаж байна.

2. Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/110 дугаар тушаалыг газрын 32 албан хаагчид танилцуулж, гарын үсэг зуруулсан.





3.Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсөн гэрээг 32 албан хаагчтай байгуулж, “Ёс зүйн зөвлөл”-өөс боловсруулсан Ёс зүйн дүрэмд “Хүүхэд хамгаалах ёс зүйн заалт”-ыг тусгахаар санал өгч хамтран ажилласан.



4.Албан хаагчдын эцэг, эх байх үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангах үүднээс ажлын цаг зохицуулалт хийж албан хаагчдын ажилдаа ирэх, тарах цагийг уян хатан болгож ажилласан.

Мөн Удирдлагын зөвлөлийн хурлаас Газрын даргаас өгсөн үүрэг, даалгаврын дагуу хүүхдүүдийн зуны амралт эхэлж, байгаатай холбогдуулан албан хаагчдаас цагийн тохируулгад хамрагдах талаарх судалгаа авсан. Судалгаанд 30 албан хаагч хамрагдсан бөгөөд 10 албан хаагч ажлын цагийн зохицуулалтад хамрагдахаар санал ирүүлсэн.

Үүнээс ар гэрийн ажлаа зохицуулах шалтгаанаар 4, ажлын бүтээмжээ дээшлүүлэх 3, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх 3 албан хаагч тус тус санал өгсөн. Саналын дагуу 11 албан хаагчийн ажлын цаг зохицуулалт хийж



Газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн Б/70 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжүүлэн ажилласан.

5.Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 30 албан хаагчийн 0-16 насны 55 хүүхдэд гарын бэлэг өгөх ажлыг зохион байгуулсан.

6.”Эрүүл аав, ээж аян”-ны хүрээнд нийт албан хаагчдаас “эрт илрүүлэгт” хамрагдсан талаар судалгаа авч, цалинтай чөлөө олгож, 10 албан хаагчийг шинээр хамруулах ажил зохион байгуулсан.



7.Хүүхдийн зураг, дүрс, мэдээллийг зөвшөөрөлгүй хувийн фэйсбүүк хуудас ба бусад хувийн нийгмийн сүлжээн дээр тавихгүй байх, Чанарын баталгаагүй, муудсан, хориглосон, чихэрлэг хоол хүнсээр хангахгүй байх талаар ёс зүйн хэмжээг албан хаагчдад сурталчилан таниулсан.



Байгууллагын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-той хамтран “Magic box” аян зохион байгуулсан. “Magic box” хайрцагийг 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд газрын угтах хэсэгт байршуулж албан хаагчдын дархлааг дэмжих бүтээгдэхүүнээр дүүргэсэн. Тус хайрцагийн зорилго нь албан хаагчид өөрт хэрэглэгдэхгүй байгаа зүйлээ бусдад өгч, өөрт хэрэгтэй зүйлээ хайрцагнаас авч идэвхитэй хамрагдсан. “Magic box” хайрцагт 23 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн цугларсан.




Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийн нэгдсэн самбарын загвар гаргаж, хийлгэн мэдээллийн ил тод байдлыг хангах арга хэмжээ авсан.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТЦЭЦЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:
НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН “ЭЦЭГ, ЭХИЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН ДАРГА Б.ОЮУН-ЭРДЭНЭ